

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	10
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн, өмчийн бодлого зохицуулалтын газар
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ  
Ц.ШАРАВЖАМЦ ТАНАА

2020.02.27 № 06/612  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Биеийн тамир, спортын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биеийн тамир, спортын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


“Мон Аэр Тур” ХХК-иас авах 21,656.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулахад 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/49 тоот албан бичгээр өглөггүй болохыг нотолсон хариу ирүүлсэн, 201,000.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь “Оршин байх” ба “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Биеийн тамир, спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Биеийн тамир, спортын газрын захирал Ц.Шаравжамц Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтыг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 2 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Биеийн тамир, спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго бол хөгжлийн чиг хандлага, хүн амын биеийн тамир, спорт, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх хэрэгцээнд нийцүүлэн судалгаанд суурилсан ажил үйлчилгээг төр, төрийн бус байгууллагын хамтын

ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, эрүүл чийрэг, өрсөлдөх ур чадвартай хүний нөөц, таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир, спортын талаас төрөөс баримтлах, бодлого чиглэлийг боловсруулах, энэ чиглэлээр салбар хоорондын үйл ажиллагааг уялдан зохицуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол;
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол;
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 24-р тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг;
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 25-р тогтоолоор Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай ;
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 276-р тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох ;
- Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Биеийн тамир спортын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Гүүксофт” ХХК-ийн Dynamic 1.0 программ хангамж ашиглаж байна.

Биеийн тамир, спортын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Биеийн тамир, спортын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн

санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 11,083,651.8 мянган төгрөгөөс тооцон 110,836.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшин 110,574.4 мянган төгрөг болж өөрчлөгдсөн.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биеийн тамир, спортын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,147.8 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,000.3	-	(1,000.3)
Авлага	687,677.6	684,850.8	(2,826.8)
Урьдчилгаа			-
Бараа материал	784,991.9	799,339.2	14,347.3
Үндсэн хөрөнгө	1,862,677.5	1,936,305.1	73,627.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,336,347.3</b>	<b>3,420,495.1</b>	<b>84,147.8</b>
Өр төлбөр	18,497.7	20,072.1	1,574.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,317,849.6	3,400,423.0	82,573.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,336,347.3</b>	<b>3,420,495.1</b>	<b>84,147.8</b>

Авлага дансны үлдэгдэл 2,826.8 мянган төгрөгөөр буурсан. Авлагын ангиллаараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн авлагын дүн 157,628.3 мянган төгрөгөөр буурч, түрээсийн болон заалны түрээсийн авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,347.3 мянган төгрөгөөр өссөн нь Үндэсний шигшээ багийн тамирчдын эм эмнэлгийн хэрэглэл, уураг амин дэм худалдан авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 61,753.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 15,000.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авсан мөн БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албанд 269,400.0 мянган төгрөгийн эмнэлгийн багаж төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй шилжүүлэн авснаар тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А-5/1382 тоот зөвшөөрлөөр 43,005.9 мянга, 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 297 тоот тогтоолоор 197,357.2 мянган төгрөг буюу нийт 240,363.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,574.4 мянган төгрөгөөр өссөн байна. Эхний үлдэгдэл 18,497.7 мянган төгрөгийг 2019 оны эхэнд барагдуулсан боловч тайлант онд нийт 20,072.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төвлөрүүлэх түрээсийн орлого 18,764.9 мянга, хувь хүний орлогын албан татварын өглөг 594.0 мянга, "Олимпус" ХХК-иас илүү шилжүүлсэн дүн 339.0 мянга, "Хас гоёл" ХХК-ний үлдэгдэл 89.0 мянга, 2019 оны эцэст эзэн тодорхойгүй 285.2 мянган төгрөг байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн санхүүгийн үр дүн 82,573.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газар нь 2019 онд 90,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 100,551.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 12 хувиар давуулан биелүүлсэн нь спорт заалны түрээсээс гадна зааланд зар сурталчилгааны самбар байршуулж нэмэлт орлого олсонтой холбоотой

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх биеийн тамир спортын хөтөлбөрт зориулан 10,709,922.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 10,621,668.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 88,254.8 мянган төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар хуваарилсан байна.

Нийт зардлын 10,619,922.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 90,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны байгууллагаас 250,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 41,388.9 мянган төгрөг буюу нийт 291,388.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 7,525.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 940.6 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 9,152.0 мянга, томилолт зочны зардалд 2,575.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 224,436.0 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 38,142.0 мянга, бусад урсгал шилжүүлэгт 4,000.0 мянга буюу нийт 286,770.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,618.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж, горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 138,010.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 26,212.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 98,273.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 13,524.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. "Мон Аэр Тур" ХХК-иас авах 21,656.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг захидал илгээж тулган баталгаажуулалт явуулахад 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/49 тоот албан бичгээр өглөггүй болохыг нотолсон хариу ирүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

2. Өмнөх оны аудитаар өгөгдсөн "2018 оны санхүүгийн тайланд 41 байгууллагын 687,677.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагийн 68,756.0 мянган төгрөгийн авлага нь 1 жилээс дээш хугацаатай авлага байна" гэсэн зөвлөмж давтагдсан, авлагыг



барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3. Биеийн тамир спортын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 6/48 тоот тушаалаар бүх албан хаагчдад 7,861.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан 25 хувиар олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэж заасантай нийцэхгүй, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 13,524.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар биеийн тамирын мэргэжлийн холбоодуудын санхүүжилт болон гүйцэтгэлийг нарийвчлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Биеийн тамир спортын газар нь мэргэжлийн холбоодууддаа санхүүжилт хуваарилдаг бөгөөд зарцуулалтанд тавих хяналт сул байна. Мэргэжлийн спортын холбоодууд нь төрийн бус байгууллагуудын статусаар ажилладаг бөгөөд ихэнх байгууллага нь мэргэжлийн санхүүгийн ажилтан байхгүй байна.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Биеийн тамир, спортын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 127 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан мөн 1 мэдээллийг огт байршуулаагүй байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 76,661.0 мянган төгрөгийн зөрчилд 7,905.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 68,756.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Биеийн тамир, спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 111,797.4 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 110,574.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Биеийн тамир, спортын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Монголын буудлага спортын холбоонд хуваарилсан санхүүжилтийн зарцуулалтыг тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 13,524.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэнд хяналт тавьж ажиллах

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### *2. Шилэн данстай холбоотой асуудал*

##### 2.1. Илрүүлэлт:

Биеийн тамир, спортын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан мөн 1 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 2.2. Эрсдэл:

Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

#### 2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

#### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,473,669,830.93</b>	<b>1,484,190,047.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,000,329.10	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	1,000,329.10	-
31110	Төгрөг	1,000,329.10	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	687,677,571.48	684,850,794.24
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	327,453,424.48	229,149,780.48
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,285,200.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	357,938,947.00	455,701,013.76
3351	Байгууллагаас авах авлага	352,856,335.00	450,618,401.76
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,082,612.00	5,082,612.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	784,991,930.35	799,339,252.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	737,790,191.85	759,437,854.46
35110	Тусгай зориулалттай материал	552,846,539.65	314,522,245.00
35130	Эм боох материал	184,943,652.20	444,915,609.46
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	47,201,738.50	39,901,398.50
35410	Бичиг хэргийн материал	29,323,550.00	16,954,350.00
35420	Аж ахуйн материал	17,878,188.50	20,947,248.50
35440	Түлш, шатах тослох материал	-	1,999,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,862,677,543.21</b>	<b>1,936,305,093.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,862,677,543.21	1,936,305,093.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,517,627,090.01	1,539,104,639.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	879,033,567.53	879,033,567.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,136,000.00)	(77,047,130.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,163,016.57	121,163,016.57
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,853,339.70)	(60,708,300.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	817,458,921.81	763,927,550.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(545,974,260.76)	(570,954,544.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	159,769,041.49	151,309,721.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(135,971,899.79)	(133,877,408.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,031,538,424.80	1,136,319,211.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(712,400,381.94)	(670,061,043.86)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	345,050,453.20	397,200,454.06
39301	Програм хангамж	26,702,800.00	89,702,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(22,419,466.80)	(33,269,465.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	340,767,120.00	340,767,120.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,336,347,374.14</b>	<b>3,420,495,141.13</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>18,497,701.00</b>	<b>20,072,092.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	18,497,701.00	20,072,092.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	18,497,701.00	19,733,092.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	594,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	18,497,701.00	19,139,092.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18,497,701.00	19,050,092.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	89,000.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	-	339,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	339,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,317,849,673.14</b>	<b>3,400,423,049.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,317,849,673.14	3,400,423,049.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,284,813,159.52	1,284,813,159.52
51101	Өмч: - төрийн	1,284,813,159.52	1,284,813,159.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	459,026,379.05	541,599,755.04
51210	Өмнөх үеийн үр дүн	471,013,027.46	459,026,379.05
51220	Тайлант үеийн үр дүн	(11,986,648.41)	82,573,375.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,574,010,134.57	1,574,010,134.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,336,347,374.14</b>	<b>3,420,495,141.13</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>11,325,242,707.00</b>	<b>11,140,012,116.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>150,185,608.00</b>	<b>367,241,106.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	150,185,608.00	367,241,106.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,185,608.00	367,241,106.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,185,608.00	97,841,106.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		269,400,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,175,057,099.00</b>	<b>10,772,771,010.80</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	9,887,685,300.00	10,481,382,017.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,887,685,300.00	10,481,382,017.80
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,287,371,799.00	291,388,993.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,204,497,995.00	250,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	82,873,804.00	41,388,993.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,337,229,355.41</b>	<b>11,057,438,740.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,337,229,355.41</b>	<b>11,057,438,740.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,267,957,055.28</b>	<b>10,889,900,437.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,356,833,187.30</b>	<b>1,369,439,532.00</b>
210101	Үндсэн цалин	471,099,039.00	527,956,968.00
210104	Урамшуулал	60,915,948.30	
210105	Гэрээт ажлын хөлс	824,818,200.00	841,482,564.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>161,899,269.10</b>	<b>169,978,721.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	161,899,269.10	134,362,990.00
210202	Тэтгэмжийн даатгал		13,072,445.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,312,472.00
210204	Ажилгүйдлийн даатгал		804,981.00
210205	Эрүүл мэндийн даатгал		18,425,833.00
